



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2020 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/123

Мандалговь

“Өгөөмөрбурхант” ХХК-тай
гэрээ байгуулах тухай

Монгол Улсын “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Аймгийн Засаг даргын Тамгын газрын 2020 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/70 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны дүгнэлтийн дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл, Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих ажил”-ын багц-2 (Дундговь, Эрдэнэдалай сум) гүйцэтгэгчээр шалгарсан “Өгөөмөрбурхант” ХХК-тай 99,939,255 (ерэн есөн сая есөн зуун гучин есөн мянга хоёр зуун тавин тав) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Баталсан ажлын зураг, төсвийн дагуу “Өвс тэжээлийн агуулах саравч шинээр барих ажил”-ын багц-2 (Дундговь, Эрдэнэдалай сум) чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Өгөөмөрбурхант” ХХК-ийн гүйцэтгэх захирал (Б.Цэрэнханд)-д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), Эрдэнэдалай сумын Засаг дарга (С.Мөнхбаатар) нарт, ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (А.Ганбат) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.ЭРДЭНЭСҮРЭН



482060512